



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/08

Цагаан-Уул сум

**Г Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн Г
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор сумын хэмжээнд 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан мэргэжлийн ангийн хүн хүч, техник хэрэгслийг бэлтгэн бэлэн байдлыг хангаж гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж ажиллахыг мэргэжлийн ангийн дарга (Г.Одгэрэл)-д үүрэг болгосугай

3. Өвс тэжээлийн нөөцийг яаралтай тасралтгүй бүрдүүлэх талаар шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.

4. Өвс тэжээлийг худалдан авах, тээвэрлэх хүргэхэд санхүүгийн түргэн шуурхай байдлыг хангаж ажиллахыг санхүүгийн албаны дарга (Ш.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.

5. Малын хорогдлын мэдээ, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг сумын хэмжээнд нэгтгэж холбогдох газарт мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, шуурхай штабын нарийн бичгийн дарга (Т.Чандмаа)-д үүрэг болгосугай.

6. Малчдад хэрэгцээтэй өвс тэжээлийн захиалга, хоол хүнс, дулаан хувцас, өргөн хэрэглээний барааны хомсдлын мэдээг цаг тухай бүрт нь авч сумын шуурхай штабт мэдээлж байхыг Хөдөө аж ахуйн тасгийн хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн (М.Оюунчимэг), Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн (М.Дуламжав) нарт үүрэг болгосугай.

7. Хаагдсан зам, даваа, цасанд дарагдсан айл өрх, малын хашааны цас гаргах ажлыг тухай бүрт нь шуурхай кохион байгуулж ажиллахыг томилгоот бүлгийн дарга (Д.Мөнх-Очир), (Багийн Засаг дарга) нарт үүрэг болгосугай.

8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ